

БАРАМИД – ИХ ХӨЛГӨНИЙ БУДДЫН СУРГААЛЫН СУУРЬ ОЙЛГОЛТ БОЛОХ НЬ

Доктор М.Гантуяа

Түлхүүр үг: Mahayana, Prajna paramita, Madhyamika, bodhisattva, shunya, absolute, knowledge, transcendent, perfection, intuition

Товч утга: Буддын сургаалд өргөн хэрэглэгддэг зургаан барамидын тухай ойлголт нь Их хөлгөний сургаалын гол онцлогийг илэрхийлнэ. Зургаан барамидын үзэл санаанаас ерөөс билиг барамидын сургаал үүсч, улмаар Их хөлгөний философийн үзэл санаа эх үндсээ авсан байдаг.

Их хөлгөний сургаал ёсоор аливаа бодгаль бие, хэл, сэтгэлийн нүгэл хилэнц, хир нисваанисаасаа ангижирснаар нирвааны амарлингуйг олох боловч тэрхүү нисваанис хилэнцид баригдан зовж байгаа бусад төрөлхтөнийг үл тоомсорлон зөвхөн өөрийн амарлингуйг эрхэмлэвээс дээд эцсийн билиг ухааны боловсронгуй төлөвт хүрч чадахгүй гэдэг. Иймээс хамаг төрөлхтөнийг зовлонгоос гэтэлгэхийг зорьдог бодьсадвын мөрөөр суралцах нь хамгийн дээд үнэн зам мөр болно. Ийнхүү бодьсадвын мөрийг номлох нь Их хөлгөний сургаалын гол агуулга болж байна. Чингэхдээ бодьсадвын гэгээрлийг олохын тулд юуны өмнө зургаан барамидыг бүрдүүлсэн байх учиртай гэж сургана.

Pāramitā (барамид)¹²⁶ хэмээх санскрит үг нь pāram, itā гэсэн хоёр үгнээс бүтэх нийлмэл үг мөн гэж зарим буддын судлаачид¹²⁷ үздэг. Pāram гэдэг нь нөгөө тал, нөгөө эрэг, цаад хязгаар гэсэн утгатай, харин itā гэдэг нь хүрсэн, туулж гарсан гэсэн утгатай гэж тэд тайлбарладаг. Гэвч нөгөө хэсэг судлаачид¹²⁸ үгийн үндэс нь parama буюу дээд оргил, цаад хязгаар, онцгой дээд, хамгийн эцсийн боловсронгуй төлөв, дээд шат гэсэн утгатай гэж тайлбарладаг. Өрнийн буддын судлаачид энэ ойлголтыг англи хэлээр “transcendental virtue” (чинад мөн чанар), “Perfect virtue” (боловсронгуй мөн чанар), “highest perfection” (дээд боловсронгуй төлөв), “complete attainment” (төгс бариа) гэх мэтээр орчуулдаг байна.

Барамидыг бүр эртний Буддын санскрит хэлт утга зохиолд дурдаж ирсэн байдаг. Гэхдээ ихэвчлэн сурч боловсрох ёстой барамидын тоог тодорхойлжээ. Тухайлбал, “Бодьсадвын газар”¹²⁹, “Их хөлгөний Судрын чимэг”¹³⁰ хэмээх сурвалжуудад 6 барамид тус бүрийг 9 бүлгээр тодорхойлсон байна. Харин “Хутагт аугаа ихэд цэнгэсэн нэрт Их хөлгөн судар”¹³¹, “Их өвөрмөц номлол”¹³² болон “Арван газрын сударт” арван барамидыг дурдаж нэрлэсэн байдаг. “Номын хуягийг барихуй”¹³³ сударт 6 барамидыг нэг бүлэгт, 10 барамидыг мөн нэг бүлэгт, нийт хоёр бүлгээр авч үзжээ. Цаг хугацааны хувьд бүр мээ 5-р зуунаас зургаан барамидыг номлож эхэлсэн бол мээ Ш зуунаас 10 барамидыг тоолж эхэлсэн байна. Энэ үеэс Энэтхэгт тооллын систем илүү боловсронгуй болсон бөгөөд аливаа асуудлын ангилал бүлэглэлийг аравтын системд оруулах хандлага өргөн болсонтой холбоотойгоор 6 барамидыг 10 барамид болгон тоолох болжээ. Энд жич тэмдэглэн хэлэхэд, барамидын тухай өгүүлсэн дээрхи судрууд нь гол төлөв бурхан Буддагийн сургаалаа айлдсан хоёр дахь шат буюу хоёр дугаар номын хүрдэнд хамаарах сурвалжууд болно. Ерөөс хоёрдугаар номын хүрдэнийг билиг барамидын сургаал бүрдүүлдэг билээ.

¹²⁶ Төвдөөр pha-rol-du-phyin-pa

¹²⁷ Bohtling, Roth, Monier Williams, E. Burnouf, B. Hodgson, M. Vassilief

¹²⁸ F. M. Thomas, T. W. Rhys Davids, W. Stede, Har Dayal

¹²⁹ Bodhisattva-bhūmi. Sanskrit Manuscript, Cambridge University Library

¹³⁰ Mahāyāna-sūtrālaṅkāra. edited by S. Levi, Paris / Mdo-sde-rgyan

¹³¹ Lalita-vistara. Монгол Ганжуур, 61 дүгээр боть

¹³² Mahā-vyutpatti, edited by Sakaki. Kyoto. Chen-po-bye-brag-tu-rtogs-par-byed-pa.

¹³³ Dharma-saṅgrāha, edited by F. Max Müller, H. Wenzel, and K. Kassawara. Oxford. Chos-phub-yu

Буддын барамидын тухай сургаалын илүү эрт үед яригдаж байсан гэдгээр нь бага хөлгөнд 6 барамидыг, харин сүүл үед яригдаж эхэлсэн гэдгээр нь 10 барамидыг Их хөлгөний үзэл гэж тайлбарлах хандлага байх боловч үнэндээ 6 барамидын тухай сургаал нь ерөөс барамидын сургаалд гол үндэс болдог юм.

Зургаан барамидыг гурав ба тав болгон хураах ёс ч бий. Судрын, Винайн, Авидармын гурван сав номыг судалж ухаарснаар санваар, самади, билиг гурав бүрэлдэнэ гэж эрт үеэс буддын сургаалд айлдаж иржээ. Ийнхүү санваар, самади, билиг гурвыг¹³⁴ үндсэн гурван цогц болгодог. Гэхдээ санваар ба самадиг салшгүй хоёр хэсэг гэсэн утгаар бүр эрт үеэс Энэтхэгийн шашин-философийн сурвалжуудад заан тодорхойлсон байна. Самади гэдгийг сэтгэлгээ гэсэн утгаар хэрэглэх, эсвэл ерөөс сэтгэлгээ¹³⁵ гэсэн ойлголтоор орлуулан тайлбарлах нь элбэг. Эндээс барамид нь санваар, сэтгэлгээ гэсэн хоёр үндсэн чанартай холбогдсон ойлголт гэж үзэж болно.

Санваар буюу зīla гэдэг нь дадал туршлага, дасгал сургуулилт гэсэн утгатай үг боловч барамидын ёсонд тасралтгүй идэвхт үйл ажиллагааг заадаг. Ингэхлээр барамидыг байнгын идэвхтэй сэтгэлгээ гэж ойлгож болно. Барамидын идэвхтэй үйл ажиллагааны чанар нь нэгд, ерөөс барамидын мөн чанар, хоёрт, бие, хэл, сэтгэлийн шинэ дээд төлөв байдал, гуравт, зөв үйл буюу буянт үйл мөн. Бодьсадва нь идэвхт үйл ажиллагаа буюу ёс суртахууны зөв хэм хэмнэлийг байнга сахисны эцэст л сая бие, хэл, сэтгэлийн ариусалд хүрнэ гэж сургадаг. Сахил буюу санваар гэдэг нь аливаа нүгэл хилэнцээс өөрийгөө ангижруулах үйл ажиллагаа юм. Буддын винайн буюу сахил санваарын ёс суртахуун (суртгаал) нь буддын сургаалын бусад бүх бүлэг бүрэлдэхүүний суурь үндэс, бие, хэл, сэтгэлийн ариуслын үндэс болдог. Их хөлгөний ёсоор санваар нь гурван төрөл байна:

1. Нүгэлт үйлийг тэвчих / nyis-spyod-sdom-pa'i-tshul-khrims / duṣkṛtasamāvaraśīla
2. Ариун буяныг сахих / dge-ba'i-chos-sdud-kyi-tshul-khrims / kuśaladhāarmasāgrahaśīla
3. хамаг амьтны тусыг санах / sems-can-don-byed-kyi- tshul-khrims / sattvaṣṛtyaśīla

Самади буюу барамидын сэтгэлгээний тал нь эгэл жирийн төрөлхтөнд байх өдөр тутмын амьдрал ахуй, сансар ертөнцийн асуудалд эргэлдэн төөрсөн хязгаарлагдмал сэтгэлгээ бус, харин бүхний түгээмэл үндэс, учир шалтгааныг ухаарч ертөнцөөс алслагдсан аглаг сэтгэлгээ буюу дияан¹³⁶ байна. Ийнхүү самади нь нэгэн үзүүрт сэтгэлээр бясалгах дияан гэсэн утгатай адилсана. Dhyāna гэсэн үгийн үндэс нь dhyā, үүнийг бясалгал хэмээн утгачлан орчуулдаг боловч гарцаагүй илэрхийлсэн орчуулга хараахан байхгүй. Судлаачид англи хэл дээр "meditation", "trance", "ecstasy", "contemplation", "rapture" гэх мэтээр орчуулдаг боловч тэдгээр нь дияаны утгыг бүрэн гүйцэд илэрхийлдэггүй болохыг мөн тайлбарласан байдаг. "Бодьсадвын газар" сударт дияаныг ухаан санааг төвлөрүүлэн тогтвржуулах арга гэсэн утгаар тайлбарласан ажээ¹³⁷. Харин "Их хөлгөний Судрын чимэгт": "дияан бол билиг ухааныг тэтгэгч" гэсэн буй¹³⁸. Бодьсадва гурван зүйлийг санаж бясалгал дияан үйлддэг:

1. Бие, сэтгэлийн баясал ханамж төрүүлэх дияан / lus-sems-bde-gnas-kyi-bsam-gtan
2. Дээд эрдмийг илт бүтээх дияан / yon-tan-mngon-sgrub-kyi-bsam-gtan
3. Хамаг амьтны тусыг санах дияан / sems-can-don-byed-kyi-bsam-gtan

¹³⁴ zīla, samādhi, prajñā / tshul-khrims, thing-nge-'dzin, she-rab

¹³⁵ Citta / sems

¹³⁶ Dhyāna / bsam-gtan

¹³⁷ Bodhisattva-bhūmi. Sanskrit Manuscript, Cambridge University Library: "citt-aikāgryaṃ citta-sthitiḥ"

¹³⁸ Mahāyāna-sūtrālaṅkāra, edited by S. Levi, Paris: "dhārayaty-adhyātmaṃ mana iti dhyānam"

Байнгын тасралтгүй идэвхт үйл ажиллагааг буюу санваарыг сахих дияан нь оюун ухаан буюу билгийн үндэс болно. Өөрөөр хэлбэл, санваарыг сахисан дияан нь билиг ухааныг төрүүлж барамидыг бүрдүүлнэ. Билиг буюу *prajcā*-г судлаачид англи хэлээр “gnosis”, “insight”, “intuition”, “transcendental idealism”, “knowledge”, “spiritual enlightenment” гэх мэтээр орчуулах ба гол төлөв мэдлэг гэсэн утгаар авч үздэг. Гахдээ мэдлэг нь харьцангуй шинжтэй байж болох бөгөөд харин билиг нь зөвхөн үнэмлэхүй түгээмэл утгатай байх учраас зөвхөн хоосон чанарыг ухаарсан дээд төрөлхтөн буюу бурхан, бодьсатва, хутагтны мэдлэг болно. Энэ утгаараа билиг барамидын үүднээс аливаа харьцангуй мэдлэг нь “буруу мэдэл” буюу мунхаг болж билиг нь тэрхүү мунхагийн эсрэг утга, мунхагийг гэтэлсэн бодьсатвын мэдлэг болдог. Билгийг дотор нь:

1. сонсохуйгаас төрсөн билиг / *thos-pa-las-byung-ba'i-she-rab* / *śrutamayijcāna*,
2. санахуйгаас төрсөн билиг / *bsam-pa-las-byung-ba'i-she-rab* / *cintāmayijcāna*,
3. бясалгалаас төрсөн билиг / *bsgom-pa-las-byung-ba'i-she-rab* / *bhāvanāmayijcāna* гэж гурав ялгадаг.

Дээр өгүүлснээр анхан эртний буддын сургаалд санваар, самади, билиг гурвыг нэгдмэл гурван чанар гэж үздэг байснаас үүдэн билгийн тухай асуудлыг дэлгэрүүлэн авч үзэх болсон бөгөөд билиг гэсэн ойлголтыг чинад дээд, түгээмэл оюун ухаан гэсэн утгаар “билиг барамид” хэмээн нэрлэх болж, үүнд зориулсан тусгай том онол сургаал гарсан нь Их хөлгөний эхлэлийг тавьсан ажээ. Билиг барамидын сургаал ёсоор билиг гэсэн ойлголтод өөр таван чинад дээд чанар буюу таван барамид дагалддаг.

Билиг барамидын анхны судар болох “Найман мянган шүлэгтэд”¹³⁹: “Билиг барамид нь ...сэтгэш үгүй дээд болой... Тэр мэт дээд мөний тул тэр нь билиг барамид хэмээгдэхийн нэрийг олох болмуй... Билиг барамид нь таван барамидын урьд яваад удирдан сайтар удирдагч болой. Энэ ёсоор таван барамид нь ямагт билиг барамидын дотор багтjou... Билиг барамид хэмээгдэх нь зургаан барамид огоот төгсгөсний нэрийдсэн үг болой... Иймийн тул билиг барамид огоот алдаршваас зургаан барамид бүгдээр огоот алдарших болмуй... Адилтгаваас их газарт цацсан хөрөнгө нөхцөлдөгчид лүгээ учиралдваас ургах болмуй. Их газар хэмээвээс тэдгээр хөрөнгийн шүтээн мөний тул их газарт шүтэж тэдгээр хөрөнгө ургаюу... Түүнчлэнхүү... билиг барамидад шүтэж таван барамид төрөх болмуй. Билиг барамид бээр огоот эзлэгдсэний тул барамид хэмээх нэрийг олюу... Тиймийн тул энэхүү билиг барамид таван барамидын урьд яваад удирдан сайтар удирдагч болой” хэмээжээ. Ийнхүү барамидын ёсоор “билиг” гэдэг нь таван үндсэн чанарыг өөртөө агуулсан ажээ. Үүнд дээр өгүүлсэн санваар, дияанаас гадна өглөг, хичээнгүй, хүлцэнгүйн таван барамид орно.

Билиг нь тасралтгүй идэвхт шинжийг буюу санваар чанарыг өөртөө агуулахдаа гадагшаа болон дотогшоо чиглэсэн үйл ажиллагааг өрнүүлдэг. Билгийн дотогшоо чиглэсэн үйл ажиллагааг дияан гэж нэрлэдэг бол гадагшаа чиглэсэн үйл ажиллагааг нь өглөг¹⁴⁰ гэнэ.

Өглөг буюу санскритаар *dāna* гэдэг нь өглөгч, өгөөмөр, уужим, ач буянтай гэсэн утгыг илэрхийлдэг. Өглөгийн тухай сургаалийг энэтхэгчүүд бүр эрт дээр үеэс буюу Ведийн үеэс номлож иржээ. Буддын Их хөлгөний сургаалд энэ ойлголтыг Би-үгүй гэсэн ойлголтод холбогдуулж философийн үүднээс авч үзсэн байна. Аливаа нэгж тусгаар бодгаль нь өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн орчлонгийн уудмын хязгааргүй төрөлхтөнтэй учир шалтгаан, үйл үрийн холбоогоор нягт харилцан хамаарах учраас “Би” хэмээн тодорхойлох нэгээхэн ч чанар үгүй, иймээс өөрийн, миний гэж бусдаас тусгаарлан харамнах нь үнэн

¹³⁹ *Aṣṭasāhasrikā* / *Brgyad-ston-pa*. Монгол Ганжуур. 44 дүгээр боть

¹⁴⁰ *Dāna* / *spyen-pa*

чанартаа өөрөөсөө харамнасан хэрэг болно хэмээн өглөгийн гүн ухааны мөн чанарыг тодорхойлдог юм. Хамаг төрөлхтөний тусыг бодсон бодьсадва нь бие, хэл, сэтгэлийн өглөгийн эзэн байна. Чингэхдээ бодьсадва нь хэнд, ямар байдлаар, яах гэж өглөг өгч байгаагаа сайтар ухаарсан байх ёстой. Ямар нэг атхаг далд санаагүй зөв сэтгэлийн ариун өглөгийг буян¹⁴¹ гэнэ. Бодьсадва нь гурван төрлийн хүмүүст өглөг өгдөг: нэгд, эцэг эх, ах дүү, төрөл төрөгсөддөө хоёрт, зовсон зүдэрсэн, ядуу хоосон, өвчин эмгэгтэй хүмүүст, гуравт, лам хувраг, сахил санваартнуудад өглөг өгдөг. Цаашлаад бодьсадва нь гурван зүйлээр өглөг өгнө:

1. Эдийн өглөг / zang-zing-gi-spyin-ba
2. Сэтгэлийн өглөг / mi-'jigs-pa'i- spyin-ba
3. Номын өглөг / chos-kyi- spyin-ba

Санваартай салшгүй холбоотой байхын зэрэгцээ санваарын чанарт зайлшгүй нэмэлт болж өгдөг барамидын өөр нэгэн ойлголт нь хүлцэнгүй¹⁴² буюу kṣānti болно. Kṣānti гэдэг нь тэвчээр хатуужил, даруу төлөв, хүлцэнгүй номой, зөөлөн энэрэнгүй гэх мэт утгыг илэрхийлнэ. A.B.Keith¹⁴³, D.T.Suzuki¹⁴⁴ зэрэг судлаачдаас, амьдралын аливаа хатуу хэцүү үйл нөлөөлөлтэй учрахдаа түүнийг дарамт, зовлон гэж хүлээж авдаггүй, харин орчлонд болж буй үй түмэн эгэл жирийн үйл хөдөлгөөний нэгээхэн хэсэг гэж үздэг сэтгэлийн тэнхээг хүлцэнгүй гэнэ гэсэн нэгэн утгатай тайлбарыг өгсөн байдаг. Хүлцэнгүй бол уур хилэн, атаа жетөө, үл нийцэл, хорсол занал гэх мэт ойлголтуудын эсрэг утга юм. Хүлцэнгүйг илэрхийлсэн гурван гол чанар байна:

1. Тэвчээр хатуужил. Бодьсадва нь хэний ч болов уур хилэн, хорсол занал, атаа жетөө, хууран мэхлэлтийг өршөөн уучлах энэрэнгүй сэтгэлтэй.
2. Тогтвор суурьшил. Бодьсадва нь дияаны сэтгэлгээгээр бодрол бясалгалд умбахдаа орчны хатуу хүтүү нөхцөл, халуун хүйтэн, өлсгөх ундаасахыг үл хайхран өөрийн билиг ухаандаа баясан сууна.
3. Үнэнийг ойлгох чадвар. Бодьсадва нь орчлонгийн түгээмэл харилцаа холбоо, шүтэн барилдлагыг ухаарсан байх тул аливаа нэгж юм үзэгдлийн утга учрыг тэрхүү түгээмэл харьцаанд олж харах билгийн нүдтэй байдаг.

Хичээнгүй барамид хэмээх нэрээр алдаршсан барамид нь хүчин чадлыг илэрхийлсэн ойлголт юм. Хичээнгүй¹⁴⁵ буюу vīrya гэдэг нь vīra буюу vīr гэсэн үгийн үндсээс бүтэх, хүчин чадалтай, сэргэлэн цовоо, эр зоригтой, баатарлаг гавьяатай гэх мэт утгыг агуулсан ойлголт болно. Эдгээр нь нүглийг дарж, буяныг бүтээн, зовлонгоос ангижирч амарлингуй гэгээрлийг олоход зайлшгүй шаардлагатай чанарууд гэж үзнэ. Их хөлгөний сурвалжуудад чухам энэ чанараар нь бурхан бодьсадва нарыг магтан дуулсан байдаг. Бурхан бодьсавын хичээнгүйн хүчийг олохын тулд:

1. Ёс суртахууны бүх сайн чанаруудыг өөртөө хуримтлуулж сахил санваарын ёс, санваарыг чандлан мөрдөх хэрэгтэй байдаг.
2. Гүн нарийн дияан бясалгалын эрдмүүдийг эхнээс нь шат дараалан нэг бүрчлэн сайтар сурч эзэмшсэн байх ёстой.
3. Зөвхөн өөрийн тусыг төдийгүй орчлонгийн хамаг амьтны тусыг бодсон туйлын нигүүлсэнгүй дээд сэтгэлийг бүтээхийг гол зорилгоо болгоно.

Энэ мэтчилэн бодьсадва нь өөрийн болон бусад бүх төрөлхөтнийг бурханы гэгээрэлд хүргэхийн тулд өглөг өгөх, санваар сахих, хүлцэнгүйг бясалгах, хичээл шамдалыг үүсгэх, дияанд суух, билигт суралцах зэргээр

¹⁴¹ Karuṇā / snying-rje

¹⁴² Kṣānti / bzod-pa

¹⁴³ A.B.Keith. Buddhist Philosophy in India and Ceylon.

¹⁴⁴ D.T.Suzuki. Outlines of Mahayana Buddhism.

¹⁴⁵ Vīrya / brtson-'grus

зургаан барамидыг ёсчлон бүтээсний эцэст чинад дээд хязгаар буюу билиг барамидыг олох болно.

Зургаан барамидын тухай Буддын сургаал нь эртний Буддын дхармын онолын нэгдмэл аргазүйг боловсруулж, төрөлхтөний чинад дээд төлвийг илэрхийлэх философийн утгуудыг тодорхойлсноороо Буддын философийн асуудлыг гүнзгийрүүлэн, Их хөлгөний философийн үзлийн үндсийг тавьсан байна.

SUMMARY

Main argument of Mahayana philosophy is the Bodhisattva Doctrine which closely connects with Paramita Doctrine. Paramita is completeness, perfection and highest state of body, mind and speech. A bodhisattva must practice basic 6 paramitas which are giving, morality, patience, energy, concentration and wisdom. They are fundamental categories of Prajna-paramita Doctrine and the factor bringing about the attainment of the Wisdom of the Highest monistic knowledge. Monism in Buddhism appeared together with Mahayana Philosophy, fundamental idea of that is based on Doctrine of Paramitas.